

Монгол Улс - Ажиллах хүчний судалгаа 2002

Үндэсний статистикийн хороо - ҮСХ

Үүссэн огноо: June 23, 2014

Вэб хуудас: <http://web.nso.mn/nadamn/index.php>

Тойм

Тодорхойлолт

ДУГААР

MNG-NSO-MN-LFS-2002-v3.0

Хувилбар

ХУВИЛБАРЫН ТАЙЛБАР

Хувилбар 2.0- Засварлагдсан мэдээллийн бааз

ҮҮССЭН ОГНОО

2004-07-29

Тойм

ТОВЧ

"Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн "Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулах" заалтыг хэрэгжүүлж хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийж, түүнийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, шинжлэн судлаачид, төр захиргааны албаны ажилтан хэн бүхэнд хөдөлмөрийн зах зээлийг зөв төлөвшүүлэн хөгжүүлэхэд ашиглах гарын авлага, тогтмол мэдээллийн эх сурвалжийг бий болгоход оршино.

СУДАЛГААНЫ НЭГЖ

- хувь хүн-өрх

Хүрээ

ТЭМДЭГЛЭЛҮҮД

АХС нь ажиллах хүчний холбогдолтой мэдээллийн сангийн эх суурийг бүрдүүлж, хүн амын ажиллах хүч, ажил эрхлэлт, ажилгүйдлийг насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, байршил, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлаар, мөн хүн амын үндсэн ажил эрхлэлт, давхар болон бүрэн бус ажил эрхлэлт, өмнөх үеийн ажил эрхлэлт, цалин, хөлстэй хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн цалин хөлсний талаарх мэдээллийг цуглуулсан. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаархи хавсарга судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, тархалт, төлөв байдал, хөдөлмөр эрхэлж буй шалтгаан, үр дагаврын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулсан.

TOPICS

Агуулга	Үгийн сан	URI
unemployment - Ажилгүйдэл [3.5]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
basic skills education - Суурь боловсрол [6.1]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
general health - Эрүүл мэнд [8.4]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
housing - Өрх [10.1]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
employment - Ажил эрхлэлт [3.1]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
working conditions - Ажиллах нөхцөл [3.6]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common

KEYWORDS

Ажиллах хүчний судалгаа

Ажиглалтын хүрээ

ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭ

Энэхүү судалгааг байршлын хувьд Монгол Улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээнд явуулахаар төлөвлөж улсын хэмжээнд 5 бүс (Улаанбаатар хот болон төв, зүүн, баруун, хангайн бүс) болгон авсан.

ХҮРЭЭ

Судалгаанд өрхийн 5 ба түүнээс дээш насны бүх гишүүд хамрагдана.

Гүйцэтгэгч болон түнш**АНХНЫ ШИНЖЭЭЧ**

Нэр	Харьяалал
Үндэсний статистикийн хороо	УИХ

БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Нэр	Харьяалал	Үүрэг
Үндэсний Статистикийн Хороо		Судалгаааны асуулгыг боловсруулахад тусалж судалгааг санхүүжүүлсэн
		Судалгаааны асуулгыг боловсруулахад тусалж судалгааг санхүүжүүлсэн

САНХҮҮЖИЛТ

Нэр	Товчлол	Үүрэг
Монгол Улсын Засгийн газар	ЗГ	
Азийн хөгжлийн банк	АХБ	
Олон улсын хөдөлмөрийн байгууллага	ОУХБ	

OTHER ACKNOWLEDGEMENTS

Нэр	Харьяалал	Үүрэг
Ноён. Ража Корали	АХБ-ны ОУ-ын зөвлөх	Судалгааны түүвэрлэлтийн загвар гаргах мөн үндсэн тайлан бэлтгэх ажилд зөвөлгөө өгсөн
Ноён. Бишнү Дэв Пант	АХБ-ны ахлах мэргэжилтэн	Судалгааны аргачлалд болон үр дүнд шинжилгээ хийхэд зөвөлгөө өгсөн.

Мета мэдээлэл боловсруулалт**БОЛОВСРУУЛСАН**

Нэр	Товчлол	Харьяалал	Үүрэг
Зундуйн Нансалмаа		ҮСГ	Баримтжуулалт хийсэн
Daniel Clarke		АНДЭЗК	Баримтжуулалтыг хянасан

МЕТА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛСАН ОГНОО

2008-05-20

DDI БИЧИГ БАРИМТЫН ХУВИЛБАР

Хувилбар 3.0

DDI БИЧИГ БАРИМТЫН ДУГААР

DDI-MNG-NSO-MN-LFS-2002-v3.0

Түүвэрлэлт

Түүвэрлэлт

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнг ашиглан дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, цэргийн хуаран зэрэг газруудыг оруулалгүйгээр Монголын нийт өрхөд үндэслэн АХС-ны түүврийн хүрээг тогтоосон. Судалгааны нутаг дэвсгэрийн үндсэн нэгжийг тогтоохдоо Улсын Их Хурлаас баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан үндсэн 5 бүсийг (Улаанбаатар хот болон төв, зүүн, баруун, хангайн бүс) дотор нь хот, хөдөө гэж нийт 9 бүлэг болгон авсан. Түүвэрлэлтийг хийхдээ 2 шатат түүврийн аргыг хэрэглэсэн. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын нэгжийг түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ээр, өрхийн түүврийн хоёр дахь нэгж (ТХШН)-ээр сонгосон. Эхний шатанд түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ийг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар, хоёр дахь шатанд ТАШН-ийг сонгосны дараа тооллогын нэгж бүрээс түүвэр олонлогийг бүрдүүлэх өрхүүдийг энгийн санамсаргүй системчилсэн цикл түүврийн аргаар сонгосон. Тус судалгааны нэг зорилго нь ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг улсын хэмжээнд болон хот, хөдөөгөөр судлан гаргах явдал байв. Энэ зорилгын хүрээнд нийт түүврийн хэмжээг 4 улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хангалттай хэмжээнд хийсэн болно. Нэг улиралд 3,200 өрх, 12,000 гаруй хүнийг түүвэрлэн хамруулж нийт дөрвөн улирлын тоо мэдээг нэгтгэн үндсэн үзүүлэлтүүдийг тооцов.

Түүврийн хэлбэлзэл

Тайланд тусгагдаагүй

Хамралтын түвшин

Судалгаанд нийт 12,800 өрх сонгогдсоноос 12,787 өрх судалгаанд хамрагдаж, хамрагдалтын түвшин 99,9 хувьтай гарав. Судалгаанд нийтдээ 49,948 хүн хамрагдаж асуулганд хариулсан

Түүврийн жин

Түүвэрт сонгогдсон нэг өрх эх олонлогийн хэдэн өрхийг төлөөлж байгааг түүврийн жинг тооцож гаргаснаар мэдэж болно. Жин гэдэг нь судалгаанд хамрагдах өрхийн сонгогдох магадлалын урвуу хэмжигдэхүүн юм.

Бид 2 шатат түүврийн арга хэрэглэсэн учир 2 төрлийн жин тооцно.

1. Сонгогдсон ТАШН нь тухайн хүрээнд тодорхойлогдсон хичнээн тооллогын нэгжийг төлөөлж байна вэ?
2. ТАШН-ээс сонгогдсон ТХШН болох өрх нь тухайн тооллогын нэгждээ хичнээн өрхийг төлөөлж байна вэ? гэдгийг харуулна.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг External Resource хэсгийн Тайлангууд хэсгийн Ажиллах хүчний судалгааны Үндсэн тайлангаас мэдэж болно.

Асуулгууд

Тойм

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан судалгааны асуулгын хуудас, зааврыг боловсруулсан. Тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн тодорхойлолт, аргачлалыг ашиглан асуулгыг боловсруулж, төгсгөлийн бүлэгт хүүхдийн хөдөлмөрийн талаарх асуултуудыг хавсаргасан. Сургалтанд хамрагдсан тоологч нар сонгогдсон бүх өрхөд очиж асуулга авч, тэдний эдийн засгийн идэвхитэй, идэвхигүй байдлын талаар иж бүрэн мэдээлэл цуглуулсан. Судалгааны асуулгын тухайн үеийн идэвхийн талаарх хэсэгт өрхийн 5 ба түүнээс дээш насны бүх хүнээс сүүлийн 7 хоногт эрхэлсэн эдийн засгийн үйл ажиллагааны талаар асууж бөглөсөн. Эдийн засгийн идэвхийг бодитой тооцохын тулд сонгогдсон өрхийн гишүүдийн эрхэлсэн эдийн засгийн бүх үйл ажиллагаа, түүний дотор өрхийн мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногоо зэрэг аж ахуйн ажлууд дахь оролцооны талаар нарийвчлан асуусан.

Манай орны эдийн засгийн үйл ажиллагаанд мал аж ахуй зонхилох үүрэгтэй байдаг. Иймд сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийг тодорхойлох аргачлалаар хүн амын жилийн турш эрхэлсэн үндсэн болон бусад үйл ажиллагаа, улирлын хэлбэлзлийн талаарх мэдээллийг авсан. ОУХБ-ын ХХУОУХ нь АХС-нд хүүхдийн хөдөлмөрийн талаархи хавсарга судалгааг оруулж, судалгааг хамтран санхүүжүүлсэн. ХХС-ны асуулга нь хүүхдийн өрх, өрхөөс гадуурх эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд дахь оролцооны талаарх мэдээллийг цуглуулахад чиглэсэн. Тухайлбал 5-17 насны хүүхэд нь гэрийн ажилд оролцож буй эсэх, хэдэн наснаасаа эхлэн өрхөөс гадуур ажил хийж эхэлсэн, ажлаас болж өвдөж гэмтсэн эсэх талаар нарийвчлан судалсан. Олон улсын стандартын дагуу АХС-ны асуулга авах өрхийн гишүүдийн насны доод хязгаарыг 5 насаар тогтоосон нь тэдний эдийн засгийн үйл ажиллагаа, боловсролын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах зорилготой байв. Энэ судалгааг зохион байгуулан явуулах ажлын хэсэг нь асуулгын хуудас, зааврыг боловсруулахдаа удирдлагын зөвлөлийн гишүүд болон холбогдох яамд, ТББ, ОУБ-уудтай зөвшилцөх, саналыг нь авах, хоёр удаа турших замаар асуулгыг хэд хэдэн удаа шинэчлэн боловсронгуй болгож эцэслэсэн. (Хавсралт 4-ыг үзнэ үү). Асуулгаар дараах мэдээллийг цуглуулсан.

Үүнд:

А Хүн ам зүйн үзүүлэлтүүд

- Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох
- Хүйс
- Төрсөн он сар өдөр, нас
- Сургуульд суралцсан, суралцаж байгаа эсэх
- Боловсролын түвшин
- Бичиг үсгийн мэдлэг
- Гэрлэлтийн байдал

Б. Сүүлийн 7 хоног болон сүүлийн 12 сарын байдлаар тодорхойлох ажиллах хүчний үзүүлэлтүүд

Тухайн үеийн идэвхи, түүнд зарцуулсан цаг

- Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн үйл ажиллагааны идэвхи
- Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цаг
- Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн бус үйл ажиллагаа
- Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн бус үйл ажиллагаанд зарцуулсан цаг
- Сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхитэй, идэвхигүй байдал
- Сүүлийн 7 хоногт (тухайн үеийн) эрхэлсэн үндсэн болон давхар ажил эрхлэлт
- Үндсэн болон давхар ажил эрхлэлтийн ажилласан хугацаа
- Сүүлийн 7 хоногт үндсэн болон давхар ажил эрхэлсэн дундаж цаг
- Үндсэн болон давхар ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангиллаар
- Үндсэн болон давхар ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдлаар
- Ажил эрхлэлт, байгууллагын төрлөөр
- Үндсэн болон давхар ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цаг
- Сүүлийн 7 хоногт (тухайн үеийн) эрхэлсэн цалин, хөлстэй үндсэн болон давхар ажил эрхэлсэн хүний тоо
- Сүүлийн 7 хоногт (тухайн үеийн) цалин, хөлстэй үндсэн болон давхар ажил эрхэлсэн ажиллагчдын цалин, орлого
- Нэмэгдэл ажил хийх хүсэл, боломж
- Нэмэгдэл ажил хийх хүсэл боломжгүй байгаа шалтгаан
- Бүрэн бус хөдөлмөр эрхэлсэн хугацаа
- Нэмэгдэл ажил хэрхэн хайсан

В. Ажилгүйдэл

- а. Ажил хийхэд бэлэн байсан эсэх
- б. Эдийн засгийн идэвхигүй байсан шалтгаан
- в. Ажил хайсан хугацаа
- г. Ямар төрлийн/ажил мэргэжлийн ажил хийх бодолтой байгаа
- д. Хичнээн төгрөгний цалин хөлс (өдрийн, сарын) авах бодолтой байгаа
- е. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн эсэх
- ё. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хугацаа
- ж. Ажил хайсан хэлбэр
- з. Ажилгүй байсан хугацаа
- Г. Байнгын эдийн засгийн идэвхи
- а. Сүүлийн 12 сарын эдийн засгийн идэвхи
- б. Сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар ажил эрхлэлт
- в. Сүүлийн 12 сарын хугацааны үндсэн ба давхар ажил эрхлэлтийн байдал, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
- г. Ажилгүй байсан хугацаа
- д. Ажил хайсан хэлбэр
- е. Сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдлаар
- ё. Сүүлийн 12 сард үндсэн болон давхар ажил эрхлэлтээс авсан дундаж цалин хөлс, орлого
- Д. Өмнөх үеийн ажил эрхлэлт
- а. Өмнөх үеийн ажил эрхлэлтийн ажил мэргэжил, ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл
- б. Хамгийн сүүлийн ажлаа хир удаан хийсэн
- в. Хамгийн сүүлийн үеийн ажил эрхлэлтийн байдал
- г. Өмнөх үеийн ажил эрхлэлтийн хамгийн сүүлчийн өдөр, хугацаа
- д. Ажиллаж байсан салбар, байгууллагын төрөл
- е. Хамгийн сүүлчийн ажлаа хийхээ больсон шалтгаан
- ё. Ажилгүй байх хугацаандаа ямар орлого, тусламжаар амьдарч байгаа
- Е. Хүүхдийн эдийн засгийн идэвхи (5-17 насны)
- а. Гэрийнхээ ажилд тусалж байгаа хэлбэрүүд
- б. Сургуульд хамрагдалт
- в. Сургуульд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан
- г. Өрхийн аж ахуйн ажилд оролцдог эсэх
- г. Анх хэдэн настайгаасаа эхэлж ажиллаж эхэлсэн
- д. Өрхийн аж ахуйд туслах, ажиллах болсон шалтгаан
- е. Өрхөөс гадуур ямар нэг ажил хийх болсон шалтгаан
- ё. Хэний удирдлага, хяналтын дор ажиллаж байгаа
- ж. Хүүхдүүд ажлын байрныхаа нөхцөлд сэтгэл ханамж ямар байдаг
- з. Хийж буй ажил нь хүүхдэд бие болон сэтгэлийн дарамт учруулдаг эсэх
- и. Шөнө оройн цагаар ажилладаг эсэх, хэр олон удаа
- й. Хүүхэд ажлаасаа болж өвдөж гэмтсэн эсэх
- к. Ямар өвчин гэмтэл авсан
- л. Олсон орлогоо юунд зарцуулдаг
- м. Өдөрт өөрт нь чөлөөт цаг гардаг эсэх

Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулалтын огноо

Эхлэх	Дуусах	Цикл
2002-10-01	2002-12-31	Нэгдүгээр улирал
2003-01-01	2003-03-31	Хоёрдугаар улирал
2003-04-01	2003-06-30	Гуравдугаар улирал
2003-07-01	2003-09-30	Дөрөвдүгээр улирал

Мэдээлэл цуглуулалтын бодлого

Face-to-face [f2f]

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Судалгааны тоологч, ахлагч нар сонгогдсон өрхүүдэд очиж 5 ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Судалгааны нэгдүгээр улирлын мэдээллийг цуглуулах ажил 2002 оны 10-12 сард, хоёрдугаар улирлынх 2003 оны 1-3 сард, гуравдугаар улирлынх 2003 оны 4-6 сард, дөрөвдүгээр улирлынх 2003 оны 7-9 сард хийгдэж дууссан. Тоологч бүрт 5-6 тооллогын нэгжийн 50-60 өрх ногдсон бөгөөд энэ судалгаа нь улирлаар явагдсан тул улирал бүрийн дараагийн сард илүү ачаалалтай ажиллаж байв. Монгол Улсад хүн амын шилжих хөдөлгөөн их байгааг харгалзан судалгаа авах үеэр өрх эзгүй байх тохиолдолд судалгаанд сонгогдсон өрхөө бүрэн хамруулахын тулд тухайн өрхөд 2-3 удаа дахин очиж, судалгаанд хамруулах ажилд хяналт тавьж ажиллав. Үүний дүнд нийт 4 улирлын хэмжээнд 12,787 өрхөөс асуулга бүрэн авч чадав.

Мэдээлэл цуглуулалт

Нэр	Товчлол	Харьяалал
Монгол Улсын Үндэсний хороо	ҮСХ	УИХ

SUPERVISION

Судалгааны ажлын хэсгийн гишүүд, байгууллагын удирдлагуудаас бүрдсэн хяналтын баг АХС-ны ажлын явцыг нийт 13 аймаг болон Улаанбаатар хотод хянаж шалган, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан. Нийслэл, аймгийн статистикийн албадын ажилтнуудыг тоологч, ахлагчаар авч ажиллуулсан нь тэдний мэдлэг чадварыг нь нэмэгдүүлэхэд тодорхой үр дүн үзүүлсэн.

Мэдээлэл боловсруулалт

Мэдээлэл засалт

АХС-ны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСГ-т, харин өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт шивж оруулах, шалгах, засварлан төвд дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн статистикийн ажиллах хүчний судалгааны баг хийж гүйцэтгэсэн. АНУ-ын Тооллогын Товчооноос боловсруулан гаргасан IMPS программыг ҮСГ-ны мэдээлэл боловсруулалтын газрын ажилтнууд хүн амын тооллого болон бусад түүвэр судалгаануудад өргөнөөр ашиглаж тодорхой туршлага дадлага эзэмшсэн тул АХС-ны мэдээллийг IMPS багц програмаар боловсруулж, мэдээллийг шалгахдаа Concor-ын засварын модулыг ашигласан.

Бусад боловсруулалт

Судалгааны мэдээллийг боловсруулж дууссаны дараа ажлын хэсэг зөвлөхийн хамт тодорхой үзүүлэлтүүд дээр статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнгийн үндсэн үзүүлэлтүүдийг бусад эх сурвалжаас авсан мэдээлэлтэй харьцуулж үзэх, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварлах, зарим үзүүлэлтийн боловсруулалтанд хэрэглэсэн томъёолол, агуулгыг лавлан тодруулсны үндсэн дээр ажлын баримт бичиг болох материалуудыг бэлтгэн гаргаж тайлан бичихэд хэрэглэв. Түүврийн алдааг IMPS программын хүрээнд CENVAR модулыг ашиглан тооцсон.

Мэдээллийн үнэлэлт

Түүвэрлэлтийн алдааны үнэлэлт

Түүвэр судалгаа хийхэд зайлшгүй яригддаг асуудал нь түүвэрлэлтийн болон түүвэрлэлтийн бус алдаа бөгөөд АХС-ны хувьд ч гэсэн үүнийг харгалзан үзэх ёстой. Түүвэрлэлтийн бус алдаа нь тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үед гарсан алдаанаас үүсэлтэй байдаг. Энэ нь судалгааны бэлтгэл үе шат, мэдээлэл цуглуулах үед хийсэн тоологчийн болон мэдээлэгчийн санамсаргүй болон санаатай хийсэн алдаа, боловсруулалтын шатанд гарсан алдааг хамруулна. Түүвэрлэлтийн бус алдааг багасгах зорилготойгоор хэд хэдэн урьдчилсан арга хэмжээ авсан. Түүвэрлэлтийн аргын нарийвчилсан төлөвлөлт; мэдээлэл цуглуулах болон боловсруулах үе шатанд хийсэн АХС-ны ажлын хэсгийн сургалт, зааварчилгаа; тоо мэдээллийг боловсруулах, цэвэрлэх, мэдээллийн уялдаа холбоог шалгах, үр дүнгийн хүснэгтийг гаргах, шивэлтийн болон хяналт, боловсруулалтын программ нь түүврийн бус алдааг багасгасан. Гэхдээ түүвэрлэлтийн бус алдаа нь түүврийн үр дүнгийн алдааны ихэнх хувийг эзэлдэг бөгөөд түүврийн дизайн болон түүвэр судалгааг явуулах үе шатуудаас хамаардаггүйг энд дурдах нь зүйтэй байх. Түүвэрлэлтийн бус алдааг тооцох арга дутмаг байдаг тул энэхүү судалгааны нийт алдааг зөвхөн түүврийн алдаагаар илэрхийлсэн болно. Нийт олонлогоос түүвэрлэн авсан ажиглалт дээр тулгуурлан үр дүнг тооцдогдоос улбаалан түүврийн алдаа гардаг. Түүврийн алдаа тухайн судалгааг хийхэд ашигласан түүврийн төрөл болон түүврийн хэмжээнээс хамаарна. Энэхүү алдааг боломжит түвшинд байлгах үүднээс түүврийн загварыг болон түүврийн хэмжээг сонгосон.

Улсын хэмжээнд тодорхойлогдсон тооллогын нэгж бүрээс тус түүвэрт сонгогдсон түүврийн нэгжээс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаасаа ямархуу хэлбэлзэлтэй байхыг түүврийн алдаа илэрхийлнэ. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнд тулгуурлан алдааг тооцсон бөгөөд зарим нэг үзүүлэлтийн алдааны хязгаар өндөр байх нь түүврийн загварыг сонгох үе шатанд харагдаж байсан.

АХС-ны мэдээллийг боловсруулахад АНУ-ын тооллогын товчооны боловсруулсан IMPS программыг ашигласан. Судалгааны түүврийн алдааг тооцохдоо IMPS-ийн түүврийн вариацийг тооцдог CENVAR модулыг ашигласан болно. Тооцоологдох ерөнхий олонлогийн үзүүлэлт болон багцлалын тооцоо бүрт CENVAR доорх үр дүнг гаргасан.

- Ерөнхий олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга
- Стандарт алдаа
- Вариацийн коэффициент
- 95 хувийн итгэмжлэгдэх интервал
- Түүврийн загварын нөлөө
- Тооцоо хийхэд ашиглагдсан ажиглалтын тоо

Түүврийн алдааны хэмжээг тооцохдоо стандарт алдааг 95.0 хувийн магадлалтай авна гэвэл 2 (харин 90.0 хувийн магадлалтай авахаар бол 1.6-аар үржүүлж)-оор үржүүлж, түүврийн тооцооны утга дээр нэмж, хасдаг. Тооцооны утга дээр стандарт алдааг 2-р үржүүлэн нэмж хассанаар уг интервал ерөнхий олонлогийн бодит утгыг агуулах магадлал 95.0 хувь болдог. CENVAR-ын модулаар тооцсон түүврийн алдаанд стандарт алдаа нь 2, итгэмжлэгдэх интервал нь 95.0 хувь байна. Хүснэгт 76-83-д түүврийн алдааны тооцоог үзүүлэв.

Хэрэглэгчийн зааварт дурдсанчлан, CENVAR модуль нь олон шатат бүлэглэсэн түүврийн аргын хувьд вариацийг тооцож гаргадаг. АХС-нд ашигласан хоёр шатат түүврийн аргын нарийвчлал, 9 бүлэг, түүврийн жингийн дүнг CENVAR модулын түүврийн загварыг тодорхойлох үе шатанд бүрэн оруулж өгсөн. Гэсэн хэдий ч түүврийн загварын зарим нэг ойлголт, тухайлбал буцаалттай системчилсэн бүлэглэсэн энгийн санамсаргүй түүврийн аргаар тодорхойлогдсон аймаг (бүс), сум (дүүрэг)-ээр бүлэглэсэн түүврийн загвар CENVAR-ын хувьд тодорхойлогдоогүй байсан. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнээс хамааран энэхүү модулаар тооцогдсон түүврийн алдаа нь бодит утга болон бодит итгэмжлэгдсэн интервалын хэмжээг нэмүү байдлаар илэрхийлсэн байж болох талтай.

Мэдээлэл үнэлэлтийн бусад хэлбэр

Тооллогын нэгж бүрээс 10 өрх түүвэрлэгдэх ёстой боловч зарим тооллогын нэгжээс 10 - аас бага өрх түүвэрлэгдсэн.

Файлын тайлбар

variable_list

АХС 2002-2003

Агуулга	Ажиллах хүчний судалгааны асуулгын хуудсаар болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуулгатай хамт цуглуулсан, өрхийн ерөнхий байдал, өрхийн гишүүдийн тухайн үеийн үйл ажиллагаа, хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаархи мэдээллийг агуулсан мэдээллийн бааз.				
Тохиолдолууд	49948				
Хувьсагч	144				
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: Id2(Өрхийн гишүүдийн хувийн дугаар), Id1(Өрхийн дугаар), V42(Үйл ажиллагааны үндсэн чиглэл)				
Хувилбар					
Гүйцэтгэгч					
Missing Data					

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V494	Id1	Өрхийн дугаар	discrete	character	
V495	Id2	Өрхийн гишүүдийн хувийн дугаар	discrete	character	
V496	D2	Тооллогын нэгжийн дугаар	contin	numeric	
V497	D3	Аймаг/ Нийслэл	discrete	numeric	
V498	D4	Сум/ дүүрэг	discrete	numeric	
V499	D5	Суурьшил	discrete	numeric	
V500	D6	Улирал	discrete	numeric	
V501	D7	Өрхийн дугаар	discrete	numeric	
V502	V1	Өрхийн гишүүдийн дугаар	discrete	numeric	
V503	V2	Өрхийн тэргүүлэгчтэй хамаарал	discrete	numeric	Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ?
V504	V3	Хүйс	discrete	numeric	Хүйс?
V505	V4a	Он	contin	numeric	Та хэдэн онд төрсөн вэ?
V506	V4b	Сар	discrete	numeric	Та хэдэн сард төрсөн вэ?
V507	V4c	Өдөр	contin	numeric	Та хэдний өдөр төрсөн вэ?
V508	V5	Нас	contin	numeric	Та хэдэн настай вэ?
V509	v6a	Суралцаж байсан эсэх	discrete	numeric	Та аль нэг шатны сургуульд сурдаг,эсвэл суралцаж байсан уу?
V510	V7	Бүрэн тэгссэн анги / эзэмшсэн боловсролын түвшин	discrete	numeric	Таны бүрэн төгссөн анги/эзэмшсэн боловсролын түвшин?
V511	V8	Бичиг үсэг мэддэг эсэх	discrete	numeric	Та бичиг үсэг мэддэг үү?
V512	V9	Гэрлэлтийн байдал	discrete	numeric	Таны гэрлэлтийн байдал?
V513	V10	Өрхийн гишүүн өөрөө хариулах боломжтой эсэх	discrete	numeric	Өрхийн гишүүн өөрөө хариулах боломжтой юу?
V514	V11	Цалин хөлстэй ажил	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Цалин хөлстэй ажил хийсэн үү?
V515	V12	Худалдаа үйлчилгээ	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Худалдаа, үйлчилгээний ажил хийсэн үү?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V516	V13	МАА ан агнуур	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт МАА, ан агнуурын ажил хийсэн үү?
V517	V14	Газар тариалан, үр тариа суулгах, арчлах, хураах үйл ажиллагаа	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Газар тариалан, үр тариа суулгах, арчлах, хураах үйл ажиллагаатай ажил хийсэн үү?
V518	V15	Ойн аж ахуй болон мод бэлтгэх	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Ойн аж ахуй болон мод бэлтгэх ажил хийсэн үү?
V519	V16	Тээврийн үйлчилгээ	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Тээврийн үйлчилгээний ажил хийсэн үү?
V520	V17	Ашигт малтмал олборлох	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Ашигт малтмал олборлох ажил хийсэн үү?
V521	V18	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх (талх, нарийн боов, ундаа, хиам хийх, гурил тээрэмдэх гм) ажил хийсэн үү?
V522	V19	Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээтэй ажил хийсэн үү?
V523	V20	Эд зүйлс, жижиг засвар үйлчилгээ хийх	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Эд зүйлс, ахуйн жижиг засвар үйлчилгээ хийх ажил хийсэн үү?
V524	V21	Нэхмэл, сүлжмэл, гутал хувцас хийх, оёх засварлах г.м	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Нэхмэл, сүлжмэл, гутал хувцас хийх, оёх, засварлах г.м ажил хийсэн үү?
V525	V22	Барилга барих, засварын үйл ажиллагаа	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Барилга барих, их засварын үйл ажиллагаа ажил хийсэн үү?
V526	V23	Хөлстэйгээр хүүхэд асрах болон хувиараа хичээл заах	contin	numeric	Та сүүлийн долоо хоногт Хөлстэйгээр хүүхэд асрах болон хувиараа хичээл заах гм ажил хийсэн үү?
V527	V24	7 хоногт хийсэн ажилд зарцуулсан нийт цаг	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн турш хийсэн тэр ажилдаа хэдэн цаг зарцуулсан бэ?
V528	V25	Хоол хийх, аяга таваг цэвэрлэх	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Хоол цай хийх, аяга таваг цэвэрлэхэд хэдэн цаг зарцуулсан вэ?
V529	V26	Гэр цэвэрлэх	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Гэр орон цэвэрлэхэд хэдэн цаг зарцуулсан вэ?
V530	V27	Хувцас угаах, индүүдэх	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Хувцас угаах, индүүдэхэд хэдэн цаг зарцуулсан вэ?
V531	V28	Гэр, байшин, эд хогшил сэргээн засах	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Гэр, байшин, эд хогшил сэргээн засахад хэдэн цаг зарцуулсан вэ?
V532	V29	Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явахад хэдэн цаг зарцуулсан вэ?
V533	V30	Хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлахад хэдэн цаг зарцуулсан вэ?
V534	V31	Ус авах	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Ус авахад хэдэн цаг зарцуулсан вэ?
V535	V32	Түлээ түлш бэлтгэх	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Түлээ, түлш бэлтгэхэд хэдэн цаг зарцуулсан вэ?
V536	V33	Өндөр настан, өвчтэй хүн асрах	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Өндөр настан, өвчтэй хүн асрахад хэдэн цаг зарцуулсан вэ?
V537	V34	Хүүхэд асрах	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Хүүхэд асрахад хэдэн цаг зарцуулсан вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V538	V35	Гэрийн тэжээвэр амьтан арчлах, ашиг олох зорилгоор бус цэцэг ногоо тарих, арчлах	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Гэрийн тэжээвэр амьтан арчлах, ашиг олох зорилгоор бус цэцэг ногоо тарих, арчлахад хэдэн цаг зарцуулсан вэ?
V539	V36	Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүйгээр оролцох	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүйгээр оролцоход хэдэн цаг зарцуулсан вэ?
V540	V37	Цалин хөлсгүйгээр хийсэн ажилд зарцуулсан нийт цаг	contin	numeric	Та сүүлийн 7 хоногийн туршид цалин хөлсгүйгээр хийсэн нийт ажилд хэдэн цаг зарцуулсан вэ?
V541	V38	24-р баганад байгаа нийт цаг	contin	numeric	
V542	V39	Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй боловч тогтмол ажилтай байсан эсэх	discrete	numeric	Та сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй боловч тогтмол ажилтай юу?
V543	V40	Үндсэн ажил мэргэжил	discrete	numeric	Та сүүлийн 7 хоногт ямар мэргэжлийн үндсэн ажил эрхэлсэн бэ?
V544	V41	Энэ ажил мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаа	contin	numeric	Та энэ ажил мэргэжлээрээ хэр удаан ажиллаж байна вэ?
V545	V42	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	contin	numeric	Таны эрхэлдэг ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?
V546	V43	Таны ажил эрхлэлтийн байдал	discrete	numeric	Таны ажил эрхлэлтийн байдал?
V547	V44	Таны ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагын төрөл	discrete	numeric	Таны ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагын төрөл ?
V548	V45	Энэ ажлыг 7 хоногт дунджаар хэдэн цаг хийх боломжтой	contin	numeric	Энэ ажлыг 7 хоногт дунджаар хэдэн цаг хийдэг вэ?
V549	V46	Таны ажиллаж буй байгууллагын үндсэн ажиллагчдын тоо	discrete	numeric	Таны ажиллаж буй байгууллагын үндсэн ажиллагчдын тоо хэд вэ ?
V550	V47	Сүүлийн 7хоногт давхар ажил хийсэн эсэх	discrete	numeric	Сүүлийн 7 хоногт давхар ажил хийсэн үү?
V551	V48	Сүүлийн 7 хоногт давхар ажил эрхлээгүй боловч тогтмол хийх давхар ажилтай эсэх	discrete	numeric	Сүүлийн 7 хоногт давхар ажил эрхлээгүй боловч тогтмол хийх давхар ажилтай юу?
V552	V49	Тогтмол хийх давхар ажлын код	contin	numeric	Та сүүлийн 7 хоногт ямар мэргэжлийн давхар ажил эрхэлсэн бэ?
V553	V50	Сүүлийн 7 хоногт давхар ажил хийсэн цаг	contin	numeric	Сүүлийн 7 хоногт давхар ажлыг хэдэн цаг хийсэн бэ?
V554	V51	Давхар ажлыг хийж байсан/байгаа хугацаа	discrete	numeric	Давхар ажлыг хэр удаан хийж байсан/байна вэ?
V555	V52	Давхар эрхэлдэг ажлын үйл ажиллагааны код	contin	numeric	Таны давхар эрхэлдэг ажлын(байгууллагын)үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?
V556	V53	Давхар ажлын ажил эрхлэлтийн байдал	discrete	numeric	Таны давхар ажлын ажил эрхлэлтийн байдал?
V557	V54	Таны давхар ажил эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын төрөл	discrete	numeric	Таны давхар ажил эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын төрөл?
V558	V55	Таны ажиллаж буй байгууллагын үндсэн ажиллагчдын тоо	discrete	numeric	Таны давхар ажиллаж буй байгууллагын үндсэн ажиллагчдын тоо?
V559	V56	Үндсэн ажлын цалин, хөлсийг авдаг давтамж	discrete	numeric	Та үндсэн ажлынхаа цалин, хөлсийг ямар хугацааны давтамжтайгаар авдаг вэ?
V560	V57a	Бэлэн мөнгөөр	contin	numeric	Таны сүүлийн 7 хоногт эрхэлсэн үндсэн ажлаасаа авсан цалин хөлс хэд вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V561	V57b	Бэлэн бус хэлбэрээр	contin	numeric	Таны сүүлийн 7 хоногт эрхэлсэн үндсэн ажлаасаа авсан цалин хөлс хэд вэ?
V562	V58a	Бэлэн мөнгөөр	contin	numeric	Сүүлийн 7 хоногт эрхэлсэн давхар ажлаасаа авсан цалин хөлс ?
V563	V58b	Бэлэн бус хэлбэрээр	contin	numeric	Сүүлийн 7 хоногт эрхэлсэн давхар ажлаасаа авсан цалин хөлс ?
V564	V59	Сүүлийн 7 хоногт нэмэгдэл ажил хийх боломжтой байсан эсэх	discrete	numeric	Та сүүлийн долоо хоногт нэмэгдэл ажил хийх боломжтой байсан уу?
V565	V60	Сүүлийн 7 хоногт нэмэгдэл ажил хийгээгүй шалтгаан	discrete	numeric	Та сүүлийн долоо хоногт яагаад нэмэгдэл ажил хийгээгүй вэ?
V566	V61	Нэмэгдэл ажил хийх бололцоотой байсан хугацаа	discrete	numeric	Та ямар хугацааны турш нэмэгдэл ажил хийх бололцоотой байсан бэ?
V567	V62	Сүүлийн 30 хоногт нэмэгдэл ажил хайсан эсэх	discrete	numeric	Та сүүлийн 30 хоногт нэмэгдэл ажил яаж хайсан бэ?
V568	V63	Сүүлийн 7 хоногт ажил хийхэд бэлэн байсан эсэх	discrete	numeric	Та сүүлийн долоо хоногт ажил хийхэд бэлэн байсан уу?
V569	V64	Хийх бодолтой байгаа ажлын код	contin	numeric	Та ямар төрлийн ажил хийх бодолтой байна бэ?
V570	V65a	Сарын цалин	contin	numeric	Энэ ажил тань наад зах нь сарын хэдэн төгрөгний цалин хөлстэй байдаг вэ?
V571	V65b	Өдрийн цалин	contin	numeric	Энэ ажил тань наад зах нь өдрийн хэдэн төгрөгний цалин хөлстэй байдаг вэ?
V572	V66	Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн эсэх	discrete	numeric	Та хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн үү?
V573	V67	Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн огноо	contin	numeric	Хөдөлмөр эрхлэлтийн албанд хэзээ бүртгүүлсэн бэ?
V574	V68	Сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэх	discrete	numeric	Та сүүлийн 30 хоногт ажил хайсан уу?
V575	V69	Сүүлийн 30 хоногт ажил хайсан байдал	discrete	numeric	Та сүүлийн 30 хоногт яаж ажил хайсан бэ?
V576	V70	Сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй шалтгаан	discrete	numeric	Та сүүлийн 30 хоногт яагаад ажил хайгаагүй вэ?
V577	V71	Ажил хийх бололцоотой байсан хугацаа	discrete	numeric	Та ямар хугацааны турш ажил хийх бололцоотой байсан бэ?
V578	V72	6 ба түүнээс дээш хугацаанд ажил хийсэн эсвэл хийхэд бэлэн байсан эсэх	discrete	numeric	Сүүлийн 12 сарын ихэнх хугацаанд (6 ба түүнээс дээш сар нь) ажил хийсэн эсвэл ажил хийхэд бэлэн байсан уу?
V579	V73	Сүүлийн 12 сарын хугацаанд ажил хийгээгүй болон хийхэд бэлэн биш байсан шалтгаан	discrete	numeric	Сүүлийн 12 сарын хугацаанд ажил хийгээгүй болон хийхэд бэлэн биш байсан (эдийн засгийн идэвхгүй) шалтгаан тань юу вэ?
V580	V74	Сүүлийн 12 сард ажил хийсэн хугацаа тань ажил хийхэд бэлэн байсан хугацаанаас их байсан эсэх	discrete	numeric	Сүүлийн 12 сард ажил хийсэн хугацаа тань ажил хийхэд бэлэн байсан хугацаанаас их байсан уу?
V581	V75	Сүүлийн 12 сард ажил хайсан байдал	discrete	numeric	Та сүүлийн 12 сард яаж ажил хийсэн бэ?
V582	V76	Ажил хийхэд бэлэн байсан болон ажил хайсан хугацаа	discrete	numeric	Хэр хугацаанд ажил хийхэд бэлэн байсан болон ажил хайсан бэ?
V583	V77	Үндсэн ажил мэргэжлийн код	contin	numeric	Та сүүлийн 12 сард ямар мэргэжлийн үндсэн ажил эрхэлсэн бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V584	V78	Эрхэлсэн ажлын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн код	contin	numeric	Таны сүүлийн 12 сард эрхэлсэн ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?
V585	V79	Энэ ажлыг эрхэлж байгаа хугацаа	discrete	numeric	Энэ ажлыг хэр удаан эрхэлж байна вэ?
V586	V80	Сүүлийн 12 сард эрхэлсэн үндсэн ажлын ажил эрхлэлтийн байдал	discrete	numeric	Тань сүүлийн 12 сард эрхэлсэн үндсэн ажлын ажил эрхлэлтийн байдал?
V587	V81a	Сарын дундаж орлого	contin	numeric	Сүүлийн 12 сарын туршид эрхэлсэн үндсэн ажлын тань сарын дундаж орлого тань хэд вэ?
V588	V81b	Өдрийн дундаж орлого	contin	numeric	Сүүлийн 12 сарын туршид эрхэлсэн үндсэн ажлын тань өдрийн дундаж орлого тань хэд вэ?
V589	V82	Сүүлийн 12 сарын туршид та давхар ажил хийсэн эсэх	discrete	numeric	Сүүлийн 12 сарын туршид та давхар ажил хийсэн үү?
V590	V83	Сүүлийн 12 эрхэлсэн давхар ажлын код	contin	numeric	Та сүүлийн 12 сард ямар мэргэжлийн давхар ажил эрхэлсэн бэ?
V591	V84	Сүүлийн 12 сард эрхэлсэн давхар ажлын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн код	contin	numeric	Таны сүүлийн 12 сард эрхэлсэн давхар ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?
V592	V85	Сүүлийн 12 сарын туршид хийсэн давхар ажлын тань ажил эрхлэлтийн байдал	discrete	numeric	Таны сүүлийн 12 сарын туршид хийсэн давхар ажлын тань ажил эрхлэлтийн байдал?
V593	V86a	Сүүлийн 12 сард эрхэлсэн нийт ажлын сарын дундаж орлого	contin	numeric	Сүүлийн 12 сард эрхэлсэн нийт ажлын тань сарын дундаж орлого хэд вэ?
V594	V86b	Сүүлийн 12 сард эрхэлсэн нийт ажлын өдрийн дундаж орлого	contin	numeric	Сүүлийн 12 сард эрхэлсэн нийт ажлын тань өдрийн дундаж орлого хэд вэ?
V595	V87	Гэрээгээр ажиллагч бол сүүлийн 12 сарын туршид хэдэн удаа ажлаа сольсон	contin	numeric	Хэрэв та гэрээгээр ажиллагч бол сүүлийн 12 сарын туршид хэдэн удаа ажлаа сольсон бэ?
V596	V88	Урьд өмнө нь ажил эрхэлж байсан эсэх	discrete	numeric	Та урьд өмнө нь ажил эрхэлж байсан уу?
V597	V89	Хамгийн сүүлд эрхэлсэн ажлын код	contin	numeric	Та хамгийн сүүлд ямар мэргэжлийн үндсэн ажил эрхэлсэн бэ?
V598	V90	Хамгийн сүүлд эрхэлж байсан ажлын үндсэн чиглэлийн код	contin	numeric	Таны хамгийн сүүлд эрхэлж байсан ажлын (байгууллагын) үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?
V599	V91	Энэ ажлыг хийсэн хугацаа	discrete	numeric	Та энэ ажлыг хэр удаан хийсэн бэ?
V600	V92	Таны хамгийн сүүлийн үеийн ажил эрхлэлтийн байдал	discrete	numeric	Таны хамгийн сүүлийн үеийн ажил эрхлэлтийн байдал?
V601	V93	Сүүлчийн ажлаа хийхээ болиод удаж байгаа хугацаа	discrete	numeric	Та сүүлчийн ажлаа хийхээ болиод хэр удаж байна вэ?
V602	V94	Таны ажиллаж байсан аж ахуй нэгж байгууллагын төрөл	discrete	numeric	Таны ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллагын төрөл?
V603	V95	Сүүлчийн ажлаа хийхээ больсон шалтгаан	discrete	numeric	Та яагаад сүүлчийн ажлаа хийхээ больсон бэ?
V604	V96a	Шалтгаан 1	discrete	numeric	Та яагаад сүүлчийн ажлаа хийхээ больсон бэ?
V605	V96b	Шалтгаан 2	discrete	numeric	Та яагаад сүүлчийн ажлаа хийхээ больсон бэ?
V606	V96c	Шалтгаан 3	discrete	numeric	Та яагаад сүүлчийн ажлаа хийхээ больсон бэ? Шалтгаан 3
V607	X1	Хүүхэд хариулж чадах эсэх	discrete	numeric	Тухайн хүүхэд хариулт өгч чадах уу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V608	X2	Ямар нэгэн сургууль курст сурч байсан эсэх	discrete	numeric	Ямар нэгэн сургууль курст сурч байсан уу?
V609	X3	Сураагүй шалтгаан	discrete	numeric	Хүүхэд . . . нь сургууль курст явж чадаагүй гол шалтгаан чинь юу вэ?
V610	X4	Өөрийн өрхийн аж ахуйн ажилд тусалдаг эсэх	discrete	numeric	- нь өөрийн өрхийн аж ахуйн ажилд тусалдаг уу?
V611	X5	Өрхийн ажилд тусалж эхэлсэн нас	contin	numeric	- нь анх хэдэн наснаасаа өрхийн аж ахуйн ажилд тусалж эхэлсэн бэ?
V612	X6	Ажил хийх туслах болсон шалтгаан	discrete	numeric	- нь яагаад ажил хийх, туслах болсон бэ?
V613	X7	Өрхөөс гадуур ямар нэгэн ажил эрхэлдэг эсэх	discrete	numeric	- нь өрхөөс гадуур ямар нэгэн ажил эрхэлдэг үү?
V614	X8	Анх өрхөөс гадуур ажил эрхэлсэн нас	contin	numeric	- нь анх хэдэн настайдаа өрхөөс гадуур ажил хийж эхэлсэн бэ?
V615	X9	Гадуур ажил эрхлэх болсон шалтгаан	discrete	numeric	- нь яагаад өрхөөс гадуур ажил хийх болсон бэ?
V616	X10	Ажлын байрны байрлал	discrete	numeric	Ажлын байр хаана байрладаг вэ?
V617	X11	Өрхөөс гадуур ажил хийж байхдаа гэрээсээ хол амьдарч байсан эсэх	discrete	numeric	Өрхөөс гадуур ажил хийж байхдаа гэрээсээ хол амьдарч байсан уу?
V618	X12	Ажил хийх хугацаандаа анх гэрээсээ хол амьдарч эхэлсэн нас	contin	numeric	Ажил хийх хугацаандаа хэдэн настайгаасаа анх гэрээсээ хол амьдарч байсан бэ?
V619	X13	Ямар нэг удирдлага дор ажиллаж байсан эсэх	discrete	numeric	Хэний удирдлага, хяналт, эсвэл анхаарал дор ажиллаж байна вэ?
V620	X14	Ажлын нөхцөлдөө сэтгэл ханамжтай эсэх	discrete	numeric	Ажлын нөхцөлдөө сэтгэл ханамжтай юу?
V621	X15	Сэтгэл ханамжгүй байгаагийн гол шалтгаан	discrete	numeric	Сэтгэл ханамжгүй байгаагийн гол шалтгаан юу вэ?
V622	X16	Эрхэлж буй ажил чинь бие болон сэтгэл санааны дарамт үзүүлдэг эсэх	discrete	numeric	Эрхэлж буй ажил чинь бие болон сэтгэл санааны дарамт үзүүлдэг үү?
V623	X171	Үзүүлсэн дарамт нөлөөний төрөл 1	discrete	numeric	Ямар дарамт нөлөө үзүүлж байна вэ?
V624	X172	Үзүүлсэн дарамт нөлөөний төрөл 2	discrete	numeric	Ямар дарамт нөлөө үзүүлж байна вэ?
V625	X173	Үзүүлсэн дарамт нөлөөний төрөл 3	discrete	numeric	Ямар дарамт нөлөө үзүүлж байна вэ?
V626	X18	Ажилдаа хөдөлмөр хамгааллын ямар нэг багаж, зэвсэг хэрэглэдэг эсэх	discrete	numeric	Ажилдаа хөдөлмөр хамгааллын ямар нэг багаж, зэвсэг хэрэглэдэг үү?
V627	X19	Сүүлийн 30 өдөр оройн болон шөнийн цагаар ажилладаг байсан давтамж	discrete	numeric	Сүүлийн 30 өдөр оройн болон шөнийн цагаар хэр олон удаа ажилладаг байсан бэ?
V628	X20	Сүүлийн 12 сард хийж буй ажлаасаа болж өвдөж гэмтсэн эсэх	discrete	numeric	. . нь сүүлийн 12 сард хийж буй ажлаасаа болж өвдөж гэмтсэн үү?
V629	X21	Өвдөж гэмтэх үед хийж байсан ажлын код	discrete	numeric	_____ хамгийн сүүлчийн удаа ямар ажил хийж байгаад өвчилж, гэмтсэн бэ?
V630	X22	Хамгийн сүүлчийн удаа хэр зэрэг хүндээр өвчилж гэмтсэн	discrete	numeric	Ер нь _____ хамгийн сүүлчийн удаа хэр зэрэг хүндээр өвчилж/ гэмтсэн бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V631	X23	Хамгийн хүндээр өртсөн өвчин	discrete	numeric	Ямар төрлийн өвчин гэмтэлд хамгийн хүндээр өртсөн бэ?
V632	X24	Өвчлөл гэмтэлтэй холбогдолтой эмчилгээний зардлыг гаргасан газар	discrete	numeric	Өвчлөл гэмтэлтэй холбогдолтой эмчилгээний зардлыг хэн гаргасан бэ?
V633	X25	Орлогын ихэнхийг зарцуулдаг төрөл	discrete	numeric	Олсон орлогынхоо дийлэнхийг юунд зарцуулдаг вэ?
V634	X26	Ажил хийхээ болиход гэр бүлд үзүүлэх нөлөө	discrete	numeric	Хэрэв ажил хийхээ боливол өөрт болон гэр бүлд чинь ямар нөлөө үзүүлэх вэ?
V635	X27	Дундаж чөлөөт цаг	contin	numeric	нд зурагт үзэх, тоглох, амрах г.м чөлөөт цаг өдөрт дунджаар хэр зэрэг гардаг вэ?
V636	Hhn	Өрхийн гишүүдийн тоо	contin	numeric	
V637	Wg	Жин	contin	numeric	

Өрхийн дугаар (Id1)

Файл: АХС 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
Бичлэгийн хэлбэр: character
Өргөн: 6

Тохиолдлууд: 49948
Хүчингүй: 0

Тайлбар

Өрх:Байнга хамтран амьдарч, нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж,нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг цусан төрлийн хамааралгүй гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно.

Ярилцлагын заавар

Тухайн улиралд хамрагдах өрхийн дугаарыг YCG-аас орон нутагт хуваарилсны дагуу ноогдсон дугаарыг бичнэ. Өрхийн дугаар нь давтагдана.

Өрхийн гишүүдийн хувийн дугаар (Id2)

Файл: АХС 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
Бичлэгийн хэлбэр: character
Өргөн: 8

Тохиолдлууд: 49948
Хүчингүй: 0

Хүрээ

Өрхийн гишүүдэд тухайн өрхөд 6 сараас илүү хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч, сурч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг бүртгэхгүй.

Ярилцлагын заавар

Энэхүү багана нь 1-15 хүртэл дугаарлагдана. Өрхийн гишүүдийн нэрсийг бичихдээ юуны өмнө өрхийн тэргүүлэгчийг бичиж бүртгэх ба өрхийн бусад гишүүдийг дараалуулан бичнэ. Ямар нэгэн шалтгаанаар 1-р баганад бичигдсэн өрхийн гишүүдийн нэрсийн дараалал алдагдвал А баганыг дахин дугаарлана. Хэрвээ тухайн өрх 15-аас дээш тооны өрхийн гишүүдтэй байвал нэмэлт асуулгын хуудсыг ашиглана. Энэ асуулгын хуудасны хувийн дугаар нь 16-аас эхлэнэ. Судалгаанд хамрагдаж байгаа өрхийн гишүүдийн тоог тодорхойлохын тулд өрхийн гишүүнээс “Танай өрх хэдэн ам бүлтэй вэ?” гэж асууна. Энэхүү асуултын хариулт өрхийн гишүүд бүгд асуулгын хуудсанд бичигдсэн эсэхийг хянахад шаардлагатай

Тооллогын нэгжийн дугаар (D2)

Файл: АХС 2002-2003

Тойм

Төрөл: Тасралтгүй
Бичлэгийн хэлбэр: numeric
Өргөн: 4
Аравтын бутархай: 0
Хүрээ: 1-1280

Тохиолдлууд: 49948
Хүчингүй: 0
Хамгийн бага: 1
Хамгийн их: 1280
Дундаж: 634.1
Стандарт хэлбэлзэл: 368.8

Ярилцлагын заавар

Тооллогын нэгжийн дугаарыг YCG-аас орон нутагт хуваарилсны дагуу ноогдсон дугаарыг бичнэ. Тооллогын нэгжийн дугаар нь давтагдах ёсгүй.

Аймаг/ Нийслэл (D3)

Файл: АХС 2002-2003

Тойм

Аймаг/ Нийслэл (D3)

Файл: АХС 2002-2003

Төрөл: Салангид
 Бичлэгийн хэлбэр: numeric
 Өргөн: 2
 Аравтын бутархай: 0
 Хүрээ: 1-22

Тохиолдлууд: 49948
 Хүчингүй: 0

Ярилцлагын заавар

Өрхийн засаг захиргааны нэгжийн хэсэгт харьяалагдах аймаг, нийслэл болон сум, дүүрэг, хорооны нэрийг бичнэ. Аймаг, хот, сум, хорооны нэгдсэн кодыг энэ зааврын Хавсралт 1 -ээс харж кодын арын дөрвөлжин нүдэнд 2 оронгоор бичнэ.

Сум/ дүүрэг (D4)

Файл: АХС 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
 Бичлэгийн хэлбэр: numeric
 Өргөн: 2
 Аравтын бутархай: 0
 Хүрээ: 1-27

Тохиолдлууд: 49948
 Хүчингүй: 0

Ярилцлагын заавар

Өрхийн засаг захиргааны нэгжийн хэсэгт харьяалагдах аймаг, нийслэл болон сум, дүүрэг, хорооны нэрийг бичнэ. Аймаг, хот, сум, хорооны нэгдсэн кодыг энэ зааврын Хавсралт 1 -ээс харж кодын арын дөрвөлжин нүдэнд 2 оронгоор бичнэ.

Суурьшил (D5)

Файл: АХС 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
 Бичлэгийн хэлбэр: numeric
 Өргөн: 1
 Аравтын бутархай: 0
 Хүрээ: 1-4

Тохиолдлууд: 49948
 Хүчингүй: 0

Ярилцлагын заавар

Суурьшилын кодыг асуулганд байгаа байршлын кодыг ашиглан тэмдэглэнэ

Улирал (D6)

Файл: АХС 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
 Бичлэгийн хэлбэр: numeric
 Өргөн: 1
 Аравтын бутархай: 0
 Хүрээ: 1-4

Тохиолдлууд: 49948
 Хүчингүй: 0

Ярилцлагын заавар

Судалгаа явуулсан улирлыг бичнэ.

Өрхийн дугаар (D7)

Файл: АХС 2002-2003

Өрхийн дугаар (D7)

Файл: AXC 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
 Бичлэгийн хэлбэр: numeric
 Өргөн: 2
 Аравтын бутархай: 0
 Хүрээ: 1-13

Тохиолдлууд: 49948
 Хүчингүй: 0

Ярилцлагын заавар

Өрхийн дугаарыг бичнэ.

Өрхийн гишүүдийн дугаар (V1)

Файл: AXC 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
 Бичлэгийн хэлбэр: numeric
 Өргөн: 2
 Аравтын бутархай: 0
 Хүрээ: 1-13

Тохиолдлууд: 49948
 Хүчингүй: 0

Ярилцлагын заавар

Өрхийн гишүүдийн нэрийг бичнэ.

Өрхийн тэргүүлэгчтэй хамаарал (V2)

Файл: AXC 2002-2003

Тойм

Төрөл: Салангид
 Бичлэгийн хэлбэр: numeric
 Өргөн: 2
 Аравтын бутархай: 0
 Хүрээ: 1-11

Тохиолдлууд: 49948 (2228828.6)
 Хүчингүй: 0 (0)

Тайлбар

